



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.01 № 01/667.

танай _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ
СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР
ДЭВШИГЧ ПҮРЭВБАТЫН
ОЮУНБИЛЭГ ТАНАА**

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Пүрэвбатын Оюунбилэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Жаргалант сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Пүрэвбатын Оюунбилэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Пүрэвбатын Оюунбилэгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Пүрэвбатын Оюунбилэгт

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 2 хуудастан

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2024 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН ЦАГААН БУРГАС БАГ 3 ДУГААР
ТОЙРОГТ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ПҮРЭВБАТЫН ОЮУНБИЛЭГИЙН 2024-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН
ХӨТӨЛБӨР

№	Хийгдэх үйл ажиллагаа	Хийгдэх хугацаа	Санхүүгийн эх үүсвэр
1	Зуны цэцэрлэгийг баг бүрт тохиромтой цаг хугацаанд нь гаргаж сургуулийн өмнөх боловсрол олгох ажлыг хөдөө багруу ойртуулж хамран сургалтыг нэмэгдүүлэх бодлого баримтална.	2024-2028 он	Улсын төсвөөр
2	Дотуур байрны хүүхдийн хоол, үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилтийг дэмжсэн эрүүл хүнсээр хангах тал дээр анхаарч, хяналтыг сайжруулна.	2024-2028 он	Улсын төсвөөр
3	"Оюунлаг Спортлог Жаргалантчууд" хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, амжилт гаргасан багш, сурагчдыг дэмжиж ажиллана.	2024-2028 он	Улсын төсвөөр
4	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог өрх гэрийн түвшинд тогтмол хийдэг эрүүл мэндийн үйлчилгээний хэлбэрийг бий болгох асуудлыг шийдвэрлүүлнэ.	2024-2028 он	Санхүүжилт шаардлагагүй
5	Эрүүл шүд хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийн шүдний өвчлөлийн асуудалд онцгой анхаарч ажиллана	2024-2028 он	Улсын төсвөөр
6	Хөдөлмөр эрхлэлтийг сайжруулж, ажилгүйдлийг бууруулах зорилгоор иргэн, хоршоо, аж ахуйн нэгжүүдийг төсөл хөтөлбөрт хамруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх бодлого баримтлана.	2024-2028 он	Улсын төсвөөр
7	Иргэдийн төлөөлөгчдийн хурал, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран иргэдэд хууль тогтоомжийг сурталчилан ажиллана.	2024-2028 он	Санхүүжилт шаардлагагүй



1720690001 3-0070605

00000001

8	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, уст цэгүүдийг сэргээн засварлаж, шинээр нэмж уст гаргах асуудлыг үе шаттай шийдвэрлэх талаар анхаарч ажиллна.	2024-2028 он	Улсын төсвөөр
9	Өвөл зуны отор нүүдлийг зохион байгуулж, зэргэлдээ аймаг сумдуудтай гэрээ хэлцэл хийж, отор нүүдэл хийх боломжийг бүрдүүлнэ.	2024-2028 он	Улсын төсвөөр
10	Жил бүр малчид тэжээлийн ургамал тариалж өвс тэжээлийн нөөцөө өөрсдөө бэлтгэх боломжийг бүрдүүлэх талаар уялдаа холбоо үүсгэн ажиллана.	2024-2028 он	Улсын төсвөөр
11	Сумын төвийн болон орон нутгийн чанартай зам, гүүрний засвар арчилгааг тогтмол хийж аюулгүй, ая тухтай замаар зорчих орчин нөхцлийг бүрдүүлнэ..	2024-2028 он	Улсын төсвөөр
12	Сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, засвар үйлчилгээг хийж, байнгын ажиллагаанд оруулна.	2024-2028 он	Улсын төсвөөр
13	Малын гаралтай түүхий эд, мах сүү, цагаан идээ, арьс шир боловсруулах жижиг үйлдвэр цех барихыг бодлогоор дэмжиж ажиллана	2024-2028 он	Улсын төсвөөр
14	Төсөв байгууллагуудын санхүүгийн мэдээлэл, суманд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн ил тод байдлыг хангуулж хэрэгжилт, үр дүнг иргэдэд тайлагнаж ажиллана.	2024-2028 он	Улсын төсвөөр
15	Гэр хорооллын газрууд гудамж хорооллын эмх цэгцгийг сайжруулах, хашаануудыг шинээр хаягжуулан бүртгэл кадастрын зураглалд оруулах.	2024-2028 он	Улсын төсвөөр
16	Төрийн албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлж, ёс зүй хандлагатай байж, иргэд сэтгэл ханамжид нийцсэн төрийн үйлчилгээг үзүүлэхэд анхаарна	2024-2028 он	Улсын төсвөөр
17	Ой, рашаан, булаг хамгаалсан, өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг төрөөс урамшуулна.	2024-2028 он	Улсын төсвөөр
18	Сумын төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлж, эко орчин бий болгох нөхцлийг бүрдүүлнэ.	2024-2028 он	Орон нутгийн төсвөөр



___000___